

2017 оны 6-р сарын 06

**ГЭРЭЭ**  
**FREEDOM GROUP-ТЭЙ ТҮНШЛЭЛ ТОГТООХ ТУХАЙ**

FREEDOM GROUP – Групп компани эрүүл мэндийг сахин хамгаалах, бэхжүүлэхэд чиглэгдсэн өндөр чанартай, ашиг тустай, амттай бүтээгдэхүүнүүдийн онцгой брэндүүдийг нэгтгэдэг бөгөөд шууд борлуулалтын аргаар дэлхий даяар бүтээгдхүүнээ түгээдэг. Бид түншүүддээ өөрсдийнхөө үр ашигтай бизнесийг бий болгох замаар боломжоо хэрэгжүүлэхэд нь туслаж сонголт хийх эрх чөлөөг өгдөг. Ингэснээр эрүүл амьдралын хэв маягийг энгийн, хялбар, ашигтайгаар хийх боломжтой болно. FREEDOM GROUP-ын Түншүүд өндөр чанартай, хямд үнэтэй бүтээгдэхүүний сонголт, өөрсдийн ажил бизнесийн арга барил, хэлбэр болон шагнал урамшууллын ойлгомжтой төлөвлөөг сонгож, өөрийгөө хөгжүүлэх, эргэн тойрны хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад нөлөө үзүүлдэгээрээ онцлогтой. Бид хамтдаа дэлхийг гайхшруулж, улам хөгжүүлцгээе!

**1. Нэр томъёо, тодорхойлолт.**

|      |                        |   |
|------|------------------------|---|
| 1.1. | Арбитрын хороо         | Компани ба Түншүүдийн төлөөллөөс байгуулагдсан байгууллага ба үндсэн чиг үүрэг нь Түншүүдээс ирүүлсэн санал гомдлыг, Түншүүд болон Компанийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх явдал юм.   |
| 1.2. | Батлан даагч           | Батлан даагч болж дэмжлэг үзүүлэх чиглэлээр өөр Түншийг өөртөө татдаг, түүнийг сургаж, мэдээлэлээр хангаж, бусад дэмжлэг үзүүлдэг хүн.  |
| 1.3. | Компанийн баримт бичиг | Компани ба Түншүүд, Компани ба Хэрэглэгчид, Түншүүд, Хэрэглэгчдийн хоорондын харилцааг зохицуулах Компанийн журам, бодлого, дотоод журмыг баталсан бөгөөд хамгийн сүүлийн үеийн хувилбарыг Компанийн вэбсайтаас үзэх боломжтой ба тодорхой Компанийн талаар өөр хэлбэрээр танилцуулахаар оруулсан болно.  |
| 1.4. | Оюуны өмч              | Барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, компанийн нэр, лого, арилжааны тэмдэг, патент, аж үйлдвэрийн загвар, ашигтай загвар, видео болон фото зураг, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл, ноу-хау, худалдаа, үйлдвэрлэлийн нууц, бүтээгдэхүүний жор найрлага, бүрэлдхүүн, бусад зүйлс нь хувь хүн ба / эсвэл хуулийн этгээдийн оюуны өмчөөр хууль тогтоомж эсвэл ажил бизнесийн практикт нийцүүлэн хүлээн зөвшөөрдсөн болно. |
| 1.5. | Хэрэглэгч              | Үүнд: Тус компанид бүртгэлтэй зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан бүтээгдэхүүн олж авах, эсвэл бизнес эрхлэх үйл ажиллагаатай холбоогүй бусад зорилгоор нэгдсэн хувь хүн, хуулийн этгээдүүд орно.   |
| 1.6. | Компани                | Хонконгт бүртгэлтэй 2507752 тоот бүртгэлийн дугаартай, rms-д бүртгэлтэй оффис бүхий FREEDOM   |

|       |                               |   |
|-------|-------------------------------|---|
|       |                               | INTERNATIONAL GROUP Limited компани. 1101-04, 38 Gloucester rd., Hong Kong.   |
| 1.7.  | Онлайн                        | Интернетэд байрлуулсан бүх эх сурвалж, нийгмийн сүлжээ, мобайл программ, вэбсайт, имэйл гэх мэт орно.   |
| 1.8.  | Түнш                          | Компанийн бүтээгдэхүүнийг сурталчлах, шинэ үйлчлүүлэгч ба түншүүдийг татах зорилгоор бүтээгдэхүүн олж авах, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Компанид бүртгэлтэй хувь хүн эсвэл хуулийн этгээдийг хэлнэ.  |
| 1.9.  | Шагнал, урамшууллын төлөвлөлт | Үйлчлүүлэгч ба түншүүдийн сүлжээ байгуулах үндсэн зарчим, түүний бүтэц, харилцан үйлчлэл, Түншүүдийн мэргэшлийн тогтолцоо, шалгуур үзүүлэлтэд хүрэх шалгуурууд - санхүүгийн, тоон үзүүлэлт, цалин хөлсний систем, давуу эрх болон Компанитай хамтран ажиллах бусад давуу талыг тодорхойлсон Компанийн болон түүний төлөөлөгчийн газрын баримт бичиг. Компани нь өөр өөр бүтээгдэхүүний брэндүүдэд тусгайлан зориулж гаргасан хэд хэдэн шагналын төлөвлөгөөтэй байж болно. |
| 1.10. | Бүтээгдхүүнүүд                | Манай Компанийн эзэмшиж буй худалдааны тэмдгийн дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тухайн ажил, бизнес хийгдэж буй нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах (борлуулах) эрхтэй.  |
| 1.11. | Бүртгэл                       | Түнш (Захилагч) -ыг гарын үсэг зурж, бүртгэлийн маягтын бөглөж, баталгаажуулсаны дагуу Компанийн мэдээллийн санд Түнш (Захилагч) болсон мэдээллийг оруулсаныг хэлнэ. Энэ нь Түншлэл болох, түүний хэсэг бүлэг, сүлжээний бүтцээр хийсэн худалдан авалтыг тооцох, хөнгөлөлт үзүүлэх, урамшуулал болон бусад арга хэмжээнд оролцох, энэхүү Гэрээ, Үйлчилгээний гэрээ, Компанийн дотоод баримт бичигт тусгах зорилгоор бүртгэл хийгддэг.                                     |

## 2. Ерөнхий заалтууд.

2.1. Шинэ түнш болгон энэхүү гэрээнд хамрагдах ба хууль ёсны насанд хүрсэн (18-аас дээш насны хүмүүст), ажил хийх бүрэн чадвартай, Түншлэлийн нөхцөлд нийцсэн байх ёстой. Компанийн Түнш бол бүртгүүлсэн газар нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд заасан журмаар байгуулагдсан хуулийн этгээд байж болно. Онцгой тохиолдолд, Түншийн хаяг, байршил холбогдох хуулиар хориглоогүй бөгөөд компанийн Түнш нь 14 наснаас дээш хүрсэн хүн байх ёстой. Ийм шийдвэрийг хувь хүн болон түүний Батлан даагчийн хандсан үндсэн дээр хүлээн авах болно.

2.2. Шинэ Түнш бүр Компанитай зөвхөн нэг Гэрээнд гарын үсэг зурж, Компанийн бизнесийн өөр чиглэлд сонирхолгүй байгаагаа баталгаажуулна. Компанид давхар бүртгэл хийхийг хатуу хориглоно.

2.3. Гэрээ нь Компанийг бүртгэснээс хойш 1 (нэг) жилийн хугацаанд хүчинтэй. Энэхүү Гэрээ дуусгавар болоход талууд аль нэг тал хугацаа дуусахаас 1 (нэг) сарын өмнө цуцлахыг хүсч байгаагаа зарлаагүй бол ижил хугацааны нөхцөлтэйгээр тухайн Гэрээг сунгаж байгуулна.

Гэрээг дахин бүртгүүлэхийн тулд Компаниас тогтоосон үнээр төлбөрийг тооцож бодогдоно. Үйлчилгээний үнэ тарифын талаархи мэдээллийг Компанийн албан ёсны төлөөлөгчийн газрын интернет сайтуудаар дамжуулан Түншлэгчдэд хүргэдэг.

2.4. Энэхүү гэрээ, Компанийн түншийн ёс зүйн дүрмийн заалтууд нь хамтдаа Компанийн бие даасан түнш болох харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

2.5. Түнш нь энэхүү Гэрээнд заасан болон Компанийн Түншийн статуст тухайн эрх үүргээ шилжүүлэхдээ, Компанийн Түнш биш болон Компанитай албан бичгээр тохиролцоо хийгээгүй тийм ойрын хамаатан садны аль нэг гишүүний зөвшөөрлөөр хийж болно. Гэрээг шилжүүлэх журам, өв залгамжлалын харилцааг Компанийн талаас нэмэлтээр зохицуулна.

### **3. Гэрээний зүйл,анги**

3.1. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар Түнш нь шууд борлуулалтын аргыг ашиглан Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бие дааж, ердийн борлуулагч статусаар эрх нь нээгдэнэ. Түншийн үүрэг бол Захиалагч хэрэглэгчийн хайж олох замаар Компанийн бүтээгдэхүүнийг тарааж түгээх явдал юм. Түнш нь шинэ Хэрэглэгчдийг өөртөө авах сонирхолтой байх бөгөөд ингэснээр тэднийг Компанийн түнш болгохын тулд сургах үүрэг хариуцлагыг давхар хүлээх болно.

3.2. Түнш нь Компани эсвэл түүний төлөөлөгчид шинэ бүтээгдэхүүн худалдан авахаас өмнө захиалж авсан ихэнх бүтээгдэхүүнээ тарааж өгсөн байх ёстой. Зөвхөн шимтгэл хураамж авах зорилгоор бараа бүтээгдхүүн худалдан авах нь урамшууллын Төлөвлөгөөний үзэл санаанд харшилж, тийм аргаар шимтгэл авч буй нь таарч тохирохгүй болохыг Компанийн зүгээс албан ёсоор зарлаж байна.

3.3. Түнш нь өөрийн Үйлчлүүлэгчдийнхээ сүлжээг өргөжүүлэх сонирхолтой бөгөөд өөртөө татсан шинэ түншүүдэд сургалт зохион байгуулж, бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ танилцуулах, хүргэлт хийх хамгийн сайн арга замыг тэдэнд танилцуулах үүрэгтэй. Үүнтэй холбогдуулан Түнш нь тэднийг сургаж, бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд нь туслах зорилгоор түүний татсан шинэ түншүүдтэй байнга холбоотой байх үүргийг хүлээнэ.

### **4. Түншийн шагнал,урамшуулал**

4.1. Түнш нь өөрийн групп хэсгийн Түншүүдийн үйл ажиллагаанаас шимтгэл хүлээж авах эрх бүхий FREEDOM GROUP-г багтсан төрөл бүрийн брэндүүдэд олгосон шагнал урамшууллын төлөвлөгөөний дагуу цалин авах боломжтой. Шимтгэлийн хэмжээг цалингийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд үүнийг Компанийн шийдвэрээр үе үе өөрчилж болно. Боломжит үйлчлүүлэгчидтэй холбоо барихдаа Түнш нь хүлээгдэж буй ажлын хөлсний талаар баталгаа өгөхгүй,мөн түүнчлэн Компанийн урамшуулал, бүтээгдэхүүн, эсвэл Төлөвлөгөөтэй холбоотой үндэслэлгүй мэдээлэл өгөх ёсгүй.

4.2. Компани нь түншүүддээ цалин хөлсийг цаг тухайд нь, бүрэн төлөх баталгаа хүлээнэ.

## 5. Бүтээгдхүүнүүд

5.1. Компани нь Түнш, түүнчлэн Захилагчид тараасан бүтээгдэхүүн өндөр чанартай болох баталгааг гаргана. Үүнтэй холбогдуулан Түнш аливаа бүтээгдэхүүнийг Компанийн урьдчилсан зөвшөөрөлтэйгээр буцааж өгөх бөгөөд өөрийн бизнес эрхэлж буй улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг чандлан хэрэгжүүлэх ёстой. Ихэнх улс оронд хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг буцааж өгөхийг хуулиар хориглосон байдаг.

5.2. Түншид худалдахаар төлөвлөсөн бүтээгдэхүүнийг дахин захиалах, / эсвэл Компанийн өгсөн сав баглаа боодол (заавар, тодорхойлолт) -д өөрчлөлт оруулахыг зөвшөөрдөггүй.

## 6. Оюуны өмч

6.1. Түнш нь Компанид харьяалагддаг нэр, барааны тэмдэг, брэнд, лого, лоозон, бэлгэ тэмдэг болон бусад тэмдэглэгээг Компанийн тусгай бичгээр зөвшөөрөлгүйгээр ашиглах эсвэл лицензийн гэрээ байгуулах эрхгүй.

6.2. Түнш нь бараа бүтээгдэхүүн, бизнес сурталчилгаа, түүний дотор өөрсдийн сайтыг бий болгох зорилгоор Интернетийг ашиглаж болно. Өөрийн вэбсайтыг үүсгэхийн тулд Түнш нь эхлээд Компанид олгосон (санал болгосон) мэдээллийг ашиглах ёстой бөгөөд хэрэв байхгүй бол сайтын бүтээх, доторхи агуулгыг Компанитай бичгээр заавал тохиролцсон байх ёстой. Түншид хамаарах сайтын нэр нь Компанийн болон түүний төлөөлөгчийн газрын албан ёсны вэбсайт нэрийг хуулбарлаж авч болохгүй (эргэлзээ төрүүлэхүйц төстэй), барааны тэмдэг, арилжааны нэр, худалдааны нэр, компанийн нэрийг оруулж болохгүй.

6.3. Түнш нь нийгмийн сүлжээн дээр түүний бүтээсэн хуудсыг ашиглан бараа бүтээгдэхүүн, бизнесээ сурталчлах боломжтой. Түүний эдгээр хуудсан дээр байрлуулсан бүтээгдэхүүн, бизнесийн талаарх мэдээлэл нь Компанийн албан ёсны баримт бичигт бүрэн нийцэх ёстой. Сайт нь заавал компанийн хараат бус Түнш эзэмшдэг (удирддаг) гэсэн мэдээллийг агуулсан байх ёстой бөгөөд энэ нь Компанийн албан ёсны хуудас биш юм.

6.4. Түнш нь Компанитай холбоотой аливаа нууц мэдээлэл, түүний дотор худалдааны нууц, ноу-хаугийн мэдээллийг нууцлах, Компанийн бизнесийн нэр хүнд, ажилчид, менежерийн нэр төр, нэр хүндэд халдсан мэдээлэл түгээхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

## 7. Түнш, түүний хараат бус байдал

7.1. Түнш нь өөрийн үйл ажиллагааг бүрэн бие даасан гэж хүлээн зөвшөөрдөг байх ёстой. Тэрээр Компанийн бүтээгдэхүүнийг сурталчлах, үйлчлүүлэгчдийг эрж хайх ажилд идэвхтэй оролцох хэрэгтэй.

Тэд албан ёсны бүртгэл, иргэний харьяалал бүхий улсад, мөн түүнчлэн шууд бизнес эрхэлж байгаа улсын холбогдох хууль тогтоомжийг зөрчихгүйгээр бие даасан Түнш болж бүтээгдэхүүнээ тогтмол хүргэдэг байна.

Энэхүү гэрээний зорилго нь Түнш, түүний батлан даагч, хамтрагч бүлгийн гишүүд ба / эсвэл Компани болон түүний төлөөлөгчийн газруудын хооронд холбоо, хамтын ажиллагаа, "ажил олгогч-ажилтны" гэсэн харилцааг бий болгохгүй. Түнш нь Компанийн өмнөөс үүрэг хүлээх, /

эсвэл хэлэлцээ хийх, Компанийг болон түүний төлөөлөгчийн газруудыг ямар ч хэлбэрээр буруутгах эрхгүй.

7.2. Компани нь Түншийг өөрийн оршин сууж буй улсын хууль тогтоомжийн дагуу хувь хүн (хувийн) бизнес эрхлэгч статустай болох, патент, лиценз авах, түүнчлэн Түнш болох статусаа хуульчлах, баталгаажуулах бусад шаардлагатай арга хэмжээнүүдийг авахыг зөвлөж байна. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Компани гэрээг цуцлах, комисс шимтгэл төлөх урамшууллаас татгалзах шалтгаан болж болно.

7.3. Түншийн үйл ажиллагаа нь түүний ажиллаж байсан газарт батлагдсан хууль тогтоомжийн дагуу явагдах ёстой. Үүнээс гадна, энэхүү гэрээний хугацаанд Түнш нь энэхүү гэрээнд заасан хугацаанд ялангуяа Компанийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөж байгаа бүтээгдэхүүнийг сурталчлах, түгээх талаар Компанитай бизнесийнхээ өрсөлдөх үйл ажиллагаа эрхлэхгүй байх. Түнш нь тухайн улсын хууль тогтоомжоор тогтоогдсон аливаа хууль бус арилжааны үйл ажиллагаанд зайлсхийх шаардлагатай. Энэхүү зүйлд заасан үүргийг Түншлэл зөрчсөн тохиолдолд Компанийн санаачилгаар гэрээг урьдчилсан болзолгүйгээр цуцлах үндэслэл болно.

## **8. Хариуцлага**

8.1. Хэрэв харилцагч Түншийн талаас Компанид ямар нэгэн өр байгаа бол Компани Түншээс төлөх шимтгэлээс зохих дүнг суутгана. Үүнээс гадна Компанийн төлөөлөгчийн газраас захиалсан болон хүлээн авсан бүтээгдэхүүний үнийг төлөөгүй (тайлангийн дагуу баталгаа гаргаж өгсөн) байвал Компани холбогдох мессеж мэдээ хүлээн авсны дараа шууд гэрээг автоматаар цуцлах болно. Гэрээ цуцлахаас өмнө Түнштэй холбоотой бүх шимтгэлээс компани заасан өрийг хасч компаниас боломжтой хугацаанд Түншид төлнө.

8.2. Түнш энэхүү гэрээний нөхцлийг ноцтой зөрчсөн тохиолдолд Арбитрын хорооны шийдвэрийг хүлээн авах хүртэл цалин хөлсийг зогсоох, эсвэл гэм буруутай Түнштэй байгуулсан энэхүү гэрээг цуцлах эрхтэй.

8.3. Түнш нь бүрэн бие даасан учраас түүний аливаа үйл ажиллагаатай холбоотой гарах зардал, алдагдлыг өөрөө бүрэн хариуцна. Ийм хариуцлагыг Компанийн зүгээс хүлээх боломжгүй.

8.4. Түнш нь өөрийн бизнесийг удирдан зохион байгуулахад шаардагдах зардал, татварын болон Компанийн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор ашиглагдах орон нутгийн татвар болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлж, нийгмийн хариуцлагыг өөрөө хүлээх болно. Компани, түүний төлөөлөгчийн газар аль ч нөхцөлд түншийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй, Түншийн хүлээн авсан шимтгэл болон бусад төлбөр, давуу эрхийн төлбөрөөс шаардлагатай татвар болон шимтгэлийг нарийн зөв тооцож гаргаж өгөх ба төлбөрийг хийх үед хариуцлага хүлээхгүй.

## **9. Бизнес эрхэлж буй нутаг дэвсгэр**

9.1. Компани нь Түншийн бизнес эрхлэх газар нутгийг тодорхойлохгүй. Гэхдээ үүнтэй зэрэгцэн Түнш нь Компанид Компанийн албан ёсны орнудаас өөр бусад орны хувьд бизнес эрхлэх

талаараа урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Компанийн зөвшөөрөөгүй улсад олон улсын бизнес эрхлэхийг хориглодог бөгөөд энэхүү гэрээг цуцлах үндэс суурь болж болох юм.

9.2.Компанид зөвхөн шинэ офис, төлөөлөгчийн газраа нээх, бүтээгдэхүүний бүртгэл, гааль болон бусад албан ёсны бүртгэлтэй холбоотой хууль ёсны журмыг хэрэгжүүлэх эрхтэй.

## **10. Гэрээг цуцлах**

10.1. Компани болон Түнш нь нөгөө талдаа энэ тусгай албан мэдэгдэл хийсний үндсэн дээр аль нэг талаас нь гэрээг цуцлах эрхтэй.

10.2. Гэрээг цуцлах тохиолдолд харилцагч Түнш нь Компанид эсвэл түүний төлөөлөгчийн газраас өмнө нь олгосон бүтээгдэхүүнтэй холбоотой төлбөрийг хийх үүрэг хүлээнэ.

10.3. Хэрэв Түнш нь гарын үсэг зурсан өдрөөс хойш 14 (арван дөрвөн) хоногийн дараа гэрээг цуцлах тухайгаа мэдэгдсэн бол Компаниас эсвэл түүний төлөөлөгчийн газраас худалдаж авсан бүтээгдэхүүнийг буцааж олгох асуудлыг Компанийн шийдвэрээр тухайн тохиолдолд тусад нь шийдвэрлэнэ. Гэсэн хэдий ч ямар ч тохиолдолд Гэрээг цуцалсны дараа Түншийн төлсөн дүнг 100% буцаан олгохыг зөвшөөрөхгүй.

10.4. Хэрэв Компаний талаас гэрээг цуцлах тохиолдолд Компани эсвэл түүний төлөөлөгчийн газрууд Түнш бие даан тогтоосон үнэ болон нөхцөлөөр борлуулсан бараа бүтээгдхүүнийг Түншээс хүлээн авах эрхтэй.

10.5. Компанийн санаачилгаар гэрээг цуцлахаас өмнө, Түнш өөрт нь мөрдөх журам, журмын зөрчлийг арилгах, зөрчлийг арилгах хүртэлх хугацааны бүртгэлийг 6 (зургаан) сарын хугацааны дотор түдгэлзүүлэх санал тавих боломжтой. Компанийн тогтоосон хугацаанд зөрчлийг арилгах шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд урьдчилсан нэмэлт нөхцөлгүйгээр энэхүү гэрээг цуцалсан гэж үзнэ.

10.6. Түншийн санаачилгаар энэхүү гэрээг цуцалсан тохиолдолд тухайн компани цуцлагдсан өдрөөс хойш 6 сарын дараа Компанийн түнш болох боломжтой.

## **11. Маргаан, санал зөрөлдөөн**

11.1. Түншүүдийн гомдол, түүний дотор Ёс зүйн дүрмийн заалт, Компанийн баримт бичигт багтсан Түншүүдэд заавал дагаж мөрдөх бусад журамтай холбоотой гомдлыг авч үзэхийн тулд Түншүүд болон Компанийн төлөөллөөс бүрдсэн байнгын Арбитрын комисс байгуулагдах болно. Арбитрын хороог байгуулах, ажиллуулах, шийдвэр гаргах журмыг Арбитрын хорооны тухай дүрмээр тогтоосон болно. Түүний шийдвэр нь эцсийн бөгөөд бүх талуудад заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

11.2. 11.1-д заасан журам.Тухайн эрх нь зөрчигдсэн хохирогч этгээдийг Түнш үйл ажиллагаагаа явуулж буй тухайн газарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмын дагуу маргааныг зохих шүүхэд шилжүүлэхэд саад болохгүй. Шүүхээс хамгаалах эрхээс татгалзах нь хууль ёсны хүчин төгөлдөр бус байна.

## 12. Төгсгөлийн заалт

12.1. Түнш нь Компанийн Ёс зүйн дүрмийг уншсаныг баталж байна. Энэхүү баримт бичигт тусгагдсан ёс зүйн хэм хэмжээ, дүрмийг Компани эдийн засгийн болон арилжааны хэрэгцээнд болон бусад шалтгаанаар шинэчлэн баталж болно. Түншийн үүрэг бол эдгээр зарчмуудын холбогдох өөрчлөлт, түүнчлэн Компанийн байгуулсан бизнес эрхлэх арга, журамд хяналт тавих явдал юм.

12.2. Түнш нь тухайн компанид хүчин төгөлдөр болсон шагнал урамшууллын төлөвлөгөөг уншиж, тэд хэрхэн ажилладаг талаар ойлголттой байгаагаа баталж байна. Түнш мэдэгдэлдээ Компанитай хамтран ажиллахдаа хүчин чармайлт гаргахгүйгээр орлого, баталгаа эсвэл бусад ашиг тус хүртэх болно гэж найдаж байгаагүй гэдгээ хүлээн зөвшөөрч тунхаглаж байгаагаа илэрхийлнэ. Түнш нь түүний амжилт нь ур чадвар, бодит хүчин чармайлтаас шууд хамаардаг болохыг хүлээн зөвшөөрч, Компанийн шийдвэрээр тогтмол хянуулж төлөвлөгөөнөөс өөр урамшуулал цалин хөлс, шимтгэл авдаггүй гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

12.3. Түнш мэдэгдлийг хүлээж аваад, Компанийн талаас энэхүү гэрээний нөхцөл, худалдаа, цалин хөлсний төлөвлөгөөний зарчимд өөрчлөлт оруулж болохыг мэдэгдэж, санал нэг байхыг илэрхийлнэ. Ийм өөрчлөлтийн талаарх мэдээллийг Компанийн [www.freedomgroupint.com](http://www.freedomgroupint.com) албан ёсны вэбсайт болон дэлхийн өнцөг булан дахь Компанийн оффисуудын вэбсайтууд дээр байрлуулж, түншийн холбогдох мэдэгдлийг имэйлээр илгээнэ.

12.4. Түнш нь Түншийн шуудангийн хаяг, түүний и-мэйл хаяг, гар утас руу илгээсэн мессежийг (маркетингийн шинжтэй мессежийг оруулаад) Компанийн зүгээс илгээсэн мэдээллийг мессежээр дамжуулж, мөн (эсвэл) Түншид тусгайлан гаргаж өгсөн аливаа хэлбэрээр хүлээж авахаа зөвшөөрч байгаагаа илэрхийлж байна.

12.5. Энэхүү гэрээнд нэгдсэнээр Түнш нь нууц мэдээллийг хадгалах нөхцөлийн дагуу хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, боловсруулах, ашиглахыг зөвшөөрч байна.

12.6. Энэхүү гэрээнд оруулсан бүх нэмэлт, өөрчлөлт нь түүний салшгүй хэсэг юм.

12.7. Энэхүү гэрээг Компанийн [www.freedomgroupint.com](http://www.freedomgroupint.com) албан ёсны вэбсайтаас үзэх боломжтой. Энэхүү гэрээнд гарын үсэг зурах үйл ажиллагааг Түнштэй нэгдэх хэлбэрээр, түүний нөхцлийг урьдчилсан болзолгүйгээр хүлээн авах замаар явуулна.

12.8. Түнш нь энэхүү гэрээтэй танилцаж, Түншийг бүртгэх явцад түүнд заасан имэйл хаягаар илгээснээр гэрээ хүчин төгөлдөр болно. Түнш рүү ийм хаягаар илгээгдсэн өдрөөс хойш 7 (долоон) хоногийн дотор Компанид элсэх саналгүй байгаа, эсвэл цаашид түнш болохоос татгалзсан болохоо мэдэгдээгүй тохиолдолд Гэрээ хүчин төгөлдөр болох үндэслэл болно.